



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 12 өдөр

Дугаар 05

Төрийн ордон, Улаанбаатар хот

ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, хүн, хуулийн этгээд, төрийн байгууллага хоорондоо цахим хэлбэрээр харилцах боломжийг олгосон зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид тусгах талаар хуулийн төсөл боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

2/Кибер аюулгүй байдлын тухай хуульд заасан онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй болон холбогдох бусад байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо, чанаарын менежментийн тогтолцоо, бизнесийн тасралтгүй байдлын менежментийн тогтолцоо, хүний хувийн мэдээллийг хамгаалах менежментийн тогтолцооны олон улсын стандартыг нэвтрүүлэх, кибер аюулгүй байдлын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх хүрээнд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

3/үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм, эдийн засгийн бүх салбарын мэдээллийн технологийн инновац, их өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун ухаан ашиглах боломжийг нээх үүднээс төрд байгаа гааль, татвар, санхүүгийн болон бусад мэдээллийг хуульд заасан журмын дагуу мэдээллийн эзнийг тодорхойлох боломжгүй болгосны үндсэн дээр нээлттэй өгөгдэл болгох, нээлттэй өгөгдлийг хиймэл оюун ухааны тусламжтай болон бусад хэлбэрээр боловсруулж ашиглах, эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг зохион байгуулах, төрийн байгууллагын суурь болон төрөлжсөн мэдээллийн санд нэгдсэн үзлэг, шалгалтыг 2024 онд багтаан хийж давхардал, зөрчлийг арилгах арга хэмжээг авах;

4/ул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг дэмжих, дотоодын нийт бүтээгдэхүүнд мэдээллийн технологийн салбарын эзлэх хувь хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мэдээллийн технологийн салбарын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, гадаадын хөрөнгө оруулалт, туршлага, ноу-хау нэвтрүүлэхийг дэмжсэн хууль тогтоомжийн төслийг боловсруулж Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

5/цахим шилжилтийн суурь дэд бүтэц болох харилцаа холбооны дэд бүтцийн давхардсан хөрөнгө оруулалтыг багасгах, дэд бүтцийн ашиглалтыг нэмэгдүүлж, иргэдийг хөдөлгөөнт интернэтээр тасралтгүй, найдвартай, хүртээмжтэйгээр хангах зорилгоор дотоодын роуминг, дэд бүтэц хуваалцах болон бусад олон улсын туршлага, арга, хэлбэрийг судалж, төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан нэвтрүүлэх боломжийг бүрдүүлэх;

6/төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хороо /Э.Батшугар/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Г.ЗАНДАНШАТАР